

Засгийн газрын 2013 оны 1 дүгээр сарын үйл ажиллагааны товч мэдээлэл

Яам	Хийсэн шинэлэг ажил	Тулгамдаж байгаа ажил	Засгийн газар, Улсын Их Хуралд өргөн барьж шийдвэрлүүлэх ажил
ХЗЯ	<p>1. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн хэрэгжилтийн үр нөлөөний тайланг нэгтгэн танилцуулав.</p> <p>2. Хуульчдын танхимд Хууль сахиулагчийн эрх зүйн байдлын тухай, Мөрдөх албаны тухай, Цагдаагийн албаны тухай, Маршалын албаны тухай хуулийн төслийн танилцуулга болон Хууль сахиулах үйл ажиллагааны тухай хуулийн төслийн үзэл баримтлалын танилцуулгыг хийж, хуулийн байгууллагуудын дунд хэлэлцүүлэг зохион байгуулав.</p> <p>3. “Монгол Улсын эрх зүйн боловсролын тогтолцоог боловсронгуй болгох асуудал” сэдвээр хуулийн байгууллагын удирдлага, хууль зүйн их, дээд сургуулийн багш, эрдэмтдийг оролцуулан олон улсын эрдэм шинжилгээний хурлыг зохион байгуулав.</p>	<p>Эрүүгийн эрх зүйн шинэтгэлийн хүрээнд дараах хуулийн төслүүдийг боловсруулж, УИХ-ын 2013 оны хаврын чуулганаар хэлэлцүүлэхээр ажиллаж байна. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> -Гэмт хэргийн тухай хууль -Гэмт хэргийг хянан шийдвэрлэх тухай хууль -Цагдаагийн албаны тухай хууль -Хууль сахиулагчийн эрх зүйн байдлын тухай хууль -Мөрдөх албаны тухай хууль -Хууль сахиулах үйл ажиллагааны тухай хууль -Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хууль -Төлбөрийн чадваргүй сэжигтэн, шүүгдэгчид үзүүлэх хууль зүйн туслалцааны тухай хууль -Зөрчлийн тухай хууль -Маршалын албаны тухай 	<p>1. “Монгол Улсын хууль тогтоомжийг 2016 он хүртэл боловсронгуй болгох Үндсэн чиглэл”-ийн төслийг Улсын Их Хурлын гишүүд, Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газар, Засгийн газрын гишүүдээс санал авч боловсруулан Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэх. /ЗГ/</p>
	<p>1. Монгол улсын Ерөнхийлөгч Ц.Элбэгдорж Дэлхийн эдийн засгийн чуулга уулзалтад оролцсон болон БНПУ-д хийсэн төрийн айлчлал, Гадаад Харилцааны сайд Л.Болд ХБНГУ-д болсон Олон улсын аюулгүй байдлын асуудлаарх Мюнхений 49 дүгээр бага хуралд, БНЭУ-д хийсэн ажлын айлчлалын бэлтгэлийг тус тус ханган, хэрэгжүүлэв.</p>	<p>1. Төрийн гадаад бодлого, үйл ажиллагааны нэгдмэл байдлыг сайжруулах журам батлах тухай</p> <p>2. Монгол, Энэтхэгийн Засгийн газар хоорондын хамтарсан хорооны 4 дүгээр</p>	

ГХЯ	<p>2.Бүх Хятадын Ардын Төлөөлөгчдийн Их Хурлын Байнгын хорооны дарга У Бангуогийн манай улсад хийсэн айлчлалын бэлтгэлийг хангаж, хэрэгжүүлэв.</p> <p>4. Монгол, Японы гадаад бодлого, аюулгүй байдал, батлан хамгаалахын анхдугаар уулзалтыг Токио хотноо зохион байгуулав.</p>	хурал зохион байгуулах тухай	
СЯ	<p>1. Сангийн сайдын 2013 оны 7 дугаар тушаалаар “Цахим тендер шалгаруулалт зохион байгуулах журам”-ыг батлав.</p> <p>2. “Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийг хуваарилах, зарцуулах, тайлагнах заавар”-ыг батлав.</p> <p>3. “Төсвийн тогтворжуулалтын санд төвлөрүүлэх орлогыг тооцох аргачлал”-ыг батлав.</p>		<p>1. Засгийн газрын 2012 оны 201 дүгээр тогтоолоор баталсан “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн хувьцааг үндэсний аж ахуйн нэгжүүдэд худалдах, иргэдэд хувьцаа эзэмшүүлэх, иргэдийн хувьцааг Засгийн газар худалдан авах үйл ажиллагааг зохицуулах журам”-д нэмэлт оруулах тухай асуудал. /ЗГ/</p> <p>2. Японы Олон Улсын хамтын ажиллагааны байгууллага /ЖАЙКА/-ын хөнгөлөлттэй зээлийн хөрөнгөөр хэрэгжүүлэх “IV цахилгаан станцын үр ашгийг дээшлүүлэх төслийн зээлийн хэлэлцээр”-ийн төсөл. /ЗГ/</p> <p>3. Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах /УИХ/</p>
ЗТЯ	<p>1. УИХ-ын 2010 оны 32 дугаар тогтоолоор батлагдсан “Төрөөс төмөр замын тээврийн талаар баримтлах бодлого”-д тусгагдсан 1 ба 2-р үе шатыг хамтад нь хэрэгжүүлэх “Шинэ төмөр зам” төслийн танилцуулгыг бэлдэж Засгийн газар, УИХ-ын байнгын хороодод танилцуулах, тухайн төслийн санхүүжилтийн тухай Засгийн газрын тогтоолын төсөл боловсруулж яамдаас санал авч Засгийн газарт хүргүүлэв.</p> <p>2. Монгол Улс, БНХАУ-ын хооронд хил орчмын нутагт суудлын автомашинаар харилцан зорчих</p>	<p>1. Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсан ажлуудын техникийн тодорхойлолт гаргах, зураг төсөлд экспертиз хийх ажил удааширч байна.</p> <p>2. “Богдхан төмөр зам” төслийн зураг төслийн санхүүжилтийг шийдвэрлэх.</p> <p>3. УБ хотын “Холимог тээврийн терминал” байгуулах</p>	<p>1. Агаарын хөлгийн шатахууныг үйлдвэрлэгчтэй шууд гэрээ байгуулах замаар худалдан авалт хийдэг байх нөхцөлийг бүрдүүлэх үүднээс асуудлыг Засгийн газрын хуралдаанаар шийдэх. /ЗГ/</p> <p>2. Монгол-Оросын хувь нийлүүлсэн нийгэмлэг “Улаанбаатар төмөр зам”-ын дэлгэрэнгүй танилцуулгыг архивын материал судлан</p>

	асуудлыг холбогдох хэлэлцээрийн хүрээнд шийдвэрлэх талаар Зам, тээврийн дэд сайд, Гадаад харилцааны дэд сайд болон Хууль зүйн яам, Хил хамгаалах ерөнхий газрын холбогдох газар, хэлтсийн дарга нар оролцсон уулзалтыг зохион байгуулав.	ажлын ТЭЗҮ хийх. 4. Төрөөс төмөр замын тээврийн талаар баримтлах бодлого батлах тухай УИХ-ын 2010 оны 32 дугаар тогтоолын 2 дахь заалтын 5-д заасан III үе шатанд баригдах хөндлөн болон баруун босоо чиглэлд тавих төмөр замын замнал /маршрут/-ыг нарийвчлан тодорхойлж УИХ-д өргөн барих.	боловсруулж, Засгийн газрын хуралдаанд танилцуулах. /ЗГ/
ХАХНХЯ	1. Хүүхэд, залуучуудыг хөгжүүлэх, хүүхдийн хөгжлийг хангах зориулалтаар барьж байгуулсан барилга, байгууламж, бий болгосон хөрөнгийн ашиглалтын өнөөгийн байдлын талаар Ерөнхий сайдад мэдээлэл хийв. 2. Ахмадын зориулалттай амралт, сувиллын газарт ахмад настны амарч сувилуулах хугацаа болон эрхийн бичгийн нэг ор хоногийн хөнгөлөлттэй үнийг тогтоон мөрдүүлэх зорилгоор “Хөнгөлөлтийн хэмжээг тогтоох тухай” болон “Журамд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” Засгийн газрын тогтоолыг 2013 оны 1 дүгээр сарын 19-ний өдрийн Засгийн газрын хуралдаанаар тус тус батлуулав.	1. “Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн” тухай НҮБ-ын конвенцийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны 2013-2016 төлөвлөгөөний төслийг боловсруулж, батлах. 2. Хүүхдийн эрхийн тухай олон улсын конвенцийн хэрэгжилтийн талаарх Монгол улсын Засгийн газрын тайланг бэлтгэж Засгийн газарт танилцуулах.	
БХЯ	1. “2013 онд Зэвсэгт хүчний оролцох энхийг дэмжих ажиллагаа болон олон улсын хамтарсан сургалт, дадлагын тухай”, “2013 онд цэргийн дүйцүүлэх албанд элсүүлэх иргэдийн тооны дээд хязгаар, цэргийн дүйцүүлэх албыг мөнгөн төлбөрийн хэлбэрээр орлуулан хаах иргэний төлөх төлбөрийн хэмжээг шинэчлэн тогтоох тухай” Засгийн газрын тогтоол батлагдав. 2. "Khaan Quest-2013" энхийг сахиулах ажиллагааны олон улсын сургуулийн төлөвлөлтийн анхан шатны бага хурлыг 2013 оны 01 дүгээр сарын 14-нөөс 18-ны өдрүүдэд зохион байгуулав.		1. “Монгол Улсын төрийн батлан хамгаалах бодлого” баримт бичгийг батлах /УИХ/ 2. 2013 онд энхийг дэмжих ажиллагаанд Зэвсэгт хүчний цэргийн баг, албан хаагчдыг оролцуулах болон олон улсын хамтарсан сургууль, дадлага зохион байгуулах тухай. /ЗГ/
	1. “Дулааны цахилгаан станц-5” төслийн хийх	1. Үнэ тарифын тухай болон	1. Хөгжлийн банкны зээлийн

<p>ЭЗХЯ</p>	<p>ажлын календарьчилсан төлөвлөгөө, танилцуулга, тендерийн бичиг баримтанд тодруулга хийж, ажлын хэсгийн гишүүдэд семинар зохион байгуулав.</p> <p>2. “Инновацийн төслийн танилцуулга”-ыг холбогдох байгууллагаас хүлээн авч, эхний дүгнэлтийг гаргав.</p> <p>3. Чөлөөт бүсийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл, үзэл баримтлал, танилцуулга, дагалдан гарах хуулийн төслүүд, холбогдох тогтоол, шийдвэр, албан тоотуудын төслийг боловсруулав. “Алтанбулаг”, “Замын-Үүд” эдийн засгийн чөлөөт бүсийн ерөнхий төлөвлөгөөний талаар судалгаа хийж танилцуулга бэлтгэв.</p> <p>4. “Монгол улсад үндэсний өрсөлдөх чадварыг дээшлүүлэх зорилгоор махны, ноос, ноолуурын, чацарганы үйлдвэрлэлийн болон аялал жуулчлалын кластер хөгжүүлэх нөхцөл байдлын үнэлгээ” сэдэвт судалгааны эцсийн тайлангийн нээлттэй хэлэлцүүлгийг хийв.</p>	<p>Худалдааны тухай хуулийн төсөл боловсруулах.</p> <p>2. “Стратегийн ач холбогдол бүхий салбарт үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгжийн гадаадын хөрөнгө оруулалтыг зохицуулах тухай” хуулийн журам батлуулах.</p> <p>3. “Хувийн хэвшлийн хөгжлийг дэмжих үндэсний стратеги”-ийн хоёрдугаар үе шат /2013-2016/-нд хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг шинэчлэн боловсруулах.</p>	<p>хөрөнгөөр хэрэгжүүлэх тухай Засгийн газрын тогтоол батлах. /ЗГ/</p> <p>2. Хөгжлийн банкны зээлийн хөрөнгөөр хэрэгжүүлэх замын ажлын тухай Засгийн газрын тогтоол батлах. /ЗГ/</p>
<p>ХЯ</p>	<p>1. “Жижиг дунд үйлдвэр, ахуйн үйлчилгээ, албан бус салбарын хөдөлмөр, нийгмийн зөвшлийн 2013-2016 оны хэлэлцээр”-ийг Хөдөлмөрийн яам, Хувийн хэвшил, жижиг дунд үйлдвэр, худалдаа, үйлчилгээ, аялал жуулчлалын салбарын ажилтны үйлдвэрчний эвлэлийн холбоотой хамтарч хийв.</p> <p>2. Хөдөлмөрийн сайдын 1/04 албан тоотуур аймгийн засаг дарга нарт “Мэргэжилтэй ажилтан бэлтгэж ажлын байраар хангах тухай”, МАОЭНХ-нд “Хамтарч ажиллах тухай” 1/13 тоот албан бичгээр “Оюутолгой” ХК-д 6600 мэргэжилтэй ажилтны захиалгыг орон нутгийн хэмжээнд авч нэгтгэн ирүүлэх, үүнд ажил олгогчдыг өргөнөөр хамруулах тухай мэдээллийг хүргүүлэв.</p>	<p>1. Хөдөлмөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл боловсруулах.</p> <p>2. БНАСАУ-аас 2013 онд Монгол Улсад хөдөлмөр эрхлэх ажиллах хүчний хэрэгцээг салбарын яамдаас аван нэгтгэж, шийдвэр гаргах,</p> <p>3. БНСУ-д ажилчид илгээх тухай санамж бичгийн өөрчлөлт, сунгалт хийх.</p>	<p>1. “Ажилтай, орлоготой Монгол хүн” Үндэсний хөтөлбөр, түүнийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг Засгийн газраар батлах. /ЗГ/</p> <p>2. “Гадаадаас ажиллах хүч, мэргэжилтэн авах, ажлын байрны төлбөрөөс чөлөөлөх тухай” Засгийн газрын тогтоол батлах. /ЗГ/</p>
	<p>1. Засгийн газрын 2013 оны 01 дүгээр сарын 12-ны хуралдаанаар идлэг шонхор шувууг арилжааны чиглэлээр гадаадад худалдаалахыг түр хориглох</p>	<p>1. Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль, Амьтны тухай хууль,</p>	<p>1. "Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай" хуулийн дагуу Ойгоос хэрэглээний мод, түлээ</p>

БОНХЯ	<p>асуудлыг батлуулав.</p> <p>2. Мазаалай баавгайг хамгаалах талуудын хоёр дахь зөвлөлдөх уулзалтыг зохион байгуулан Мазаалай баавгайг хамгаалах хөтөлбөрийн үйл ажиллганы төлөвлөгөө, төсөв боловсруулав.</p> <p>3. “Автотээврийн хэрэгслээс ялгарах хорт хий, утааны тортогжилтыг бууруулах төхөөрөмж нийлүүлэх, суурилуулах” ажлын гүйцэтгэгийг шалгаруулах тендерийн шалгаруулалтыг эхлүүлэв.</p>	<p>Усны тухай хуулийг дагалдан гарах журмын төслийг боловсруулж, батлах.</p>	<p>бэлтгэж ашигласны болон усны нөөц ашигласны төлбөрийн хувь, хэмжээг тогтоох, хөнгөлөх тухай Засгийн газрын тогтоол. /ЗГ/</p> <p>2. “Байгаль орчны стратегийн болон хуримтлагдах нөлөөллийн үнэлгээний журам”, “Байгаль орчны нөлөөллийн үнэлгээний журам” батлах. /ЗГ/</p>
ЭМЯ	<p>1. Түлэнхийн төвийг шинээр барьж ашиглалтад орох хүртэл ГССҮТ-ийн байранд шилжиж ирсэн түлэнхийн эмгэгтэй өвчтөнүүдийн эмчилгээ, үйлчилгээний тасралтгүй байдлыг хангах, дүүргийн нэгдсэн болон бусад эмнэлгүүдэд тараан байршуулах асуудлыг судлан шийдвэрлэхээр болов.</p>	<p>1. Нийслэлийн дүүргийн нэгдсэн эмнэлгүүдэд осол, гэмтэл, түлэнхийг эмчлэх тасгийг нээн ажиллуулах ажлыг тус тус шуурхай зохион байгуулах.</p>	<p>1. Эрүүл ахуйн тухай хуулийн шинэчилсэн найруулга. /УИХ/</p>
БХБЯ	<p>1. Барилгын салбарт хэрэгжүүлэх хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн “Цэнхэр карт” дэд хөтөлбөрийн төслийг төрийн бус байгууллагуудтай хамтран боловсруулав.</p> <p>2. "100 000 айлын орон сууц" төсөл хэрэгжүүлэх ажлын хүрээнд нийт 21 аймгийн хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө боловсруулахаар тусгагдсаны дагуу 11 аймагт орон сууцны хорооллын хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө боловсруулах ажлын даалгавар, тендерийн баримт бичгийг боловсруулав.</p>	<p>1. Барилгын материалын сорил шинжилгээний лаборатори байгуулах асуудлыг цогц байдлаар шийдвэрлэх хөтөлбөрийг боловсруулж, яамдаас санал авах.</p>	<p>1. “Улаанбаатар хотыг 2020 он хүртэл хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөө”-ний тодотголын баримт бичгийг батлуулах. /УИХ/</p> <p>2. Улаанбаатар хот болон орон нутагт баригдах орон сууцны хотхон хорооллын инженерийн дэд бүтцийн барилга байгууламж, шугам сүлжээний ажлын жагсаалтыг боловсруулж хэлэлцүүлэх. /ЗГ/</p> <p>3. “Газрын тухай”, “Газрын төлбөрийн тухай”, “Газрын кадастрын тухай” хуулиудын шинэчилсэн найруулга, “Геодези, зураг зүйн тухай” хуулинд нэмэлт өөрчлөлт оруулах тухай, “Газар албадан чөлөөлөх тухай” хуулиудын төсөл. /УИХ/</p>

<p>ЭХЯ</p>	<p>1. 2013 оныг Эрчим хүчний хэмнэлт, үр ашгийг дээшлүүлэх жил болгон зарлаж, хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө гарган ажиллаж байна.</p> <p>2. Мандалговь-Тавантолгойн 110 кВ-ын цахилгаан дамжуулах агаарын шугам, дэд станц, Мандалговь, Чойрын дэд станцын өргөтгөл, Тавантолгой-Манлай сумын 35 кВ-ын цахилгаан дамжуулах агаарын шугам, дэд станцад техникийн комисс ажиллуулж хүчдэлд залгав.</p> <p>3. УС-15-д 300 Гкал/ц хүчин чадалтай дулааны станц барих асуудлыг Засгийн газрын 2013 оны 01 дүгээр сарын 26-ний 35 дугаар тогтоолоор ажиллаж байна.</p>	<p>1.Эгийн голын усан цахилгаан станцыг барьж байгуулах бодлогын шийдвэрийг Засгийн газрын хуралдаанд хэлэлцүүлж гаргуулах</p>	<p>1.“Эрчим хүчний хөгжил, стратегийн болон нормативын баримт бичиг боловсруулах, эрчим хүчний үндэсний балансыг тооцоолохтой холбогдсон зардлыг санхүүжүүлэх журам”-ын төсөл. /ЗГ/</p>
<p>ССАЖЯ</p>	<p>1. Соёл, спорт, аялал жуулчлалын сайдын “Монгол батаарын түр музей байгуулах тухай” 2013 оны А/01, “Палеонтологийн ZXXCZ музей байгуулах тухай” А/02, “Археологийн музей байгуулах тухай” А/03 тоот тушаал гаргаж, дээрх ажлуудыг зохион байгуулах ажлын хэсэг байгуулан ажиллаж байна.</p> <p>2. Булган аймгийн Баяннуурын Шороон бумбагарын сэргээн засварлах болон авран хамгаалах ажлын гүйцэтгэлийг хэрхэн шийдвэрлэх талаар ажлын хэсгийг хуралдуулж, ханын зургийг хуулах нь зүйтэй гэсэн дүгнэлт гаргав.</p> <p>3. Монгол улсын Засгийн газрын хуралдаанаар олимп, дэлхий, тивийн наадамд амжилттай оролцож, онцгой амжилт гаргаж медаль хүртсэн тамирчин, түүний дасгалжуулагч нарт олгох Засгийн газрын мөнгөн шагналд 330.0 сая төгрөгийн шагналыг 90 тамирчин, 25 дасгалжуулагчидад олгуулж, 2013 оноос мөрдөх Засгийн газраас олгох мөнгөн шагналын журмыг шинэчлэн батлуулав.</p> <p>4. Монголын аялал жуулчлалын салбарын цаашдын чиг хандлагыг тодорхойлох зорилгоор “Монголын аялал жуулчлалын форум”-ыг 01 дүгээр сарын 28-29-ны өдрүүдэд амжилттай зохион байгуулав.</p>	<p>1. Үлэг гүрвэлийн музейн байрны асуудлыг шийдвэрлэх</p>	

<p>ҮХААЯ</p>	<p>1. Засгийн газрын тогтоолоор “Хөдөө аж ахуйн бирж” төрийн өмчит компани байгуулав.</p> <p>2. Ерөнхий сайдын ивээл дор Хөдөлмөрийн яам, мэргэжлийн нэгдсэн холбоодтой хамтран “Монгол гоёл, Монгол идээ, Монгол бэлэг” уриатай “Цагаан сар үзэсгэлэн худалдаа-2013” арга хэмжээг Мишээл экспо, АСА цирк, IT world зэрэг газруудад тус тус зохион байгуулав.</p> <p>3. “Өргөн хэрэглээний хүнсний жагсаалт батлах журам”, “Стратегийн улирлын нөөц бүрдүүлэх зарцуулах журам”, “Баяжуулагч бэлдмэл, нэмэлт хөрөнгийг бүртгэх, нийтийн хэрэгцээнд гаргах журам”, “Хүнсний аюулгүй байдлын Үндэсний зөвлөлийн дүрэм, ажиллах журмын төсөл”-ийг тус тус боловсруулан Сайдын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэхэд бэлэн болгов.</p>	<p>1. “Сайншанд” аж үйлдвэрийн цогцолборын үйл ажиллагааг эхлүүлэх.</p> <p>2. Хөдөө аж ахуйн биржийг туршилтын журмаар ажиллуулж эхлүүлэх.</p> <p>3. Малчдын хоршоог хөгжүүлэх Мастер төлөвлөгөөг боловсруулах.</p>	<p>1. Төрийн болон орон нутгийн өмчийн эд хөрөнгийн тооллогын нэгдсэн дүн, төрийн өмчөөс орон нутгийн өмчид эд хөрөнгө шилжүүлэх тухай Засгийн газрын тогтоолын төсөл /ЗГ/</p>
<p>УУЯ</p>	<p>1. “Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн эргэлтэд хяналт тавих тухай” хуулийн шинэчилсэн найруулгын төсөл, “Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хууль”-ийн нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийг тус тус хэлэлцэж батлуулав.</p> <p>2. Газрын тосны хайгуулын Сүхбаатар XVII талбайд газрын тостой холбогдсон үйл ажиллагаа явуулахаар БХГ байгуулах “Вульф петролеум” ХК-ийн гэрээг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэн Засгийн газрын тогтоолоор батлуулсан. Газрын тосны хайгуулын Хэрлэн тохой-XXVIII талбайд газрын тостой холбогдсон үйл ажиллагаа явуулахаар БХГ байгуулах “Хонгконг Вэлпэк Индастриал” компанийн гэрээг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэн ҮАБЗ-д танилцуулахаар дэмжигдэв.</p>	<p>1. Монгол Улсад шатдаг занар эрэх, хайх, олборлох, боловсруулах, ашиглах асуудлыг судлан, нийлэг газрын тос, хийн үйлдвэрлэлийн цогцолбор байгуулах, эрх зүйн орчинг боловсронгуй болгох, “Шатдаг занар” бодлого, хөтөлбөрийн төсөл боловсруулах.</p> <p>2. Алт олборлож угаах, хүлээлцэх, хадгалах, хамгаалах, тээвэрлэх, улсад тушаах, борлуулах журмын төслийг боловсруулах.</p> <p>3. Цацраг идэвхт ашигт малтмалын ордуудын төрийн эзэмшлийн хувь, хэмжээ болон холбогдох хуулийн хэрэгжилтэд санал боловсруулах.</p>	<p>1. “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн үйл ажиллагааг эрчимжүүлэх тухай Засгийн газрын тогтоолын төсөл боловсруулж, хэлэлцүүлэх /ЗГ/</p> <p>2. Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн эргэлтэд хяналт тавих үүрэг бүхий Мэргэжлийн зөвлөлийн дүрэм батлуулах /ЗГ/</p>
	<p>1. “Боловсролын технологийн цахим сан”</p>		<p>1. “Суралцагчийн сургалтын</p>

<p>БШУЯ</p>	<p>www.etd.edu.mn цахим хуудсыг албан ёсоор нээж, эхний ээлжинд 4 багшийн шилдэг технологийг байршуулж, танилцуулав.</p> <p>2. “Авъяас”, “Ном” хөтөлбөрийн хүрээнд хийгдэх телевизийн багц нэвтрүүлгийг МҮОНТ болон ТВ8 телевизээр тодорхой өдөр, цагт нэвтрүүлж, хүүхдийн авъяасыг хөгжүүлэх, ном унших арга зүйг түгээн дэлгэрүүлэх чиглэлийн арга хэмжээг тогтмол болгов.</p>	<p>төлбөр, амьжиргааны зардалд зориулан олгох улсын төсвийн оролцоотой эх үүсвэрийг бүрдүүлэх, эргэн төлүүлэх, сургалтын зээлийг хөнгөлөх, хүчингүй болгох журам” батлах тухай Улсын их хурлын тогтоолын үзэл баримтлал. /ЗГ/</p> <p>2. Герман-Монголын технологийн дээд сургууль байгуулах үзэл баримтлал батлах. /ЗГ/</p>
--------------------	--	---

ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР